

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая

Жилийн анхны зүүд



Японд “Жилийн анхны зүүд”-ээр тэр жилээ мэргэлдэг соёл байдаг. Эдогийн үед бий болсон “一富士二鷹三茄子(Нэгд Фүжи, хоёрт Така, гуравт Насүби)” гэдэг нь 富士(Фүжи/Фүжи уул): “無事(Бүжи/Эсэн мэнд)”, “不死(Фүши/Энх мөнх)”, 鷹(Така/шонхор шувуу): “高い(Такай/Өндөр)”, 茄子(Насүби/Хаш ногоо): “成す(Насү/Биелүүлэх)”-тэй тус тус авиа нийлүүлсэн үгнүүд бөгөөд жилийн анхны зүүдэнд эдгээр зүйлс ирвэл бэлэг дэмбэрэлтэй гэж ярьдаг.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг.

(<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)





Онцгой тохиолдолд залгах утасны дугаар “110” болон “119”. Цагдаагийн газарт холбогддог “110” нь гэмт хэрэг, хулгай, зам тээврийн осол гарсан үед мэдүүлэх дугаар юм. Гал унтраах албанд холбогддог “119” дугаар руу гал түймэр болон түргэн тусламжийн үед залгана. Аль аль нь онцгой тохиолдлоос өөр үед яавч залгаж болохгүй дугаар юм.

110 дугаар руу залгавал, **дараах** зүйлсийг мэдүүлнэ.

1 Юу болсон (Хулгай, зам тээврийн осол гэх мэт юу болсон талаар аль болох дэлгэрэнгүй мэдүүлнэ.)

2 Хэзээ, хаана болсон

3 Гэмт хэрэгтний талаар (Ямар хүн, хэд орчим насны, өмссөн хувцас зэрэг мэдэж байгаа хүрээндээ мэдүүлнэ.)

Яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагагүй зүйлийн талаар 110 дугаар руу дуудлага өгөхөөр, яаралтай хэрэг, осол зэрэгт авах хариу арга хэмжээ оройтох шалтгаан нь болно. Бэрхшээлтэй асуудал юм уу сэтгэл зовоож буй зүйлийн тухай бол Цагдаагийн газарын Зөвлөгөө өгөх дугаар (#9110)-ыг ашиглаарай.

119 дугаар руу **гал түймр** ийн үед болон **түргэн тусламж** ийн үед залгана.

— Гал түймрийн тохиолдолд —

消防署	あなた
消防です。火事ですか、救急ですか。	火事です。
住所はどこですか？	●●市（●●区）●●町●丁目●番地です。 ◀Гал гарсан газрын хаягийг мэдэгдэнэ. Мэдэхгүй тохиолдолд, тэмдэг болохуйц байшин барилга юм уу замын уулзварын нэрийг мэдэгдэнэ.
なにが燃えていますか？	●●が燃えています。 ◀Шатаж байгаа газар, шатаж байгаа юмыг мэдэгдэнэ.
燃え方やけが人は？	例：けが人が一人います。逃げ遅れている人がいます。天井に火が届いています。 ◀Гал түймрийн байдлыг мэдэгдэнэ.

— Түргэн тусламжийн тохиолдолд —

消防署	あなた
消防です。火事ですか、救急ですか。	救急です。
住所はどこですか？	●●市（●●区）●●町●丁目●番地です。 ◀Одоо байгаа газрынхаа хаягийг мэдэгдэнэ. Мэдэхгүй тохиолдолд, тэмдэг болохуйц байшин барилга юм уу замын уулзварын нэрийг мэдэгдэнэ.
どうしましたか？	例：胸が痛いです。 同僚が倒れて意識がありません。 ◀Хэн, хэзээнээс эхлэн, ямар зовиуртай байгааг мэдэгдэнэ.
あなたの名前と連絡先を教えてください。	●●です。電話番号は●●●●●●です。 ◀Гал унтраах албаны командлагч дэлгэрэнгүй шинж тэмдгийн талаар асуух тохиолдол байдаг. Боломжийнхоо хэрээр хариулаарай.

* Энэ жишээ бол түгээмэл байдаг асуулт хариултын жишээ.

Гэнэт гэмтэж бэртэх юм уу өвчин туссан үед, түргэн тусламжийн машин дуудсан нь дээр үү, одоо даруй эмнэлэг рүү явсан нь дээр үү гэж эргэлзсэн тохиолдолд (#7119)-ийн Түргэн тусламжийн Утсаар зөвлөгөө өгөх үйлчилгээг ашиглаарай.

出典元：（一財）日本防火・防災協会HP、総務省消防庁HP（<https://www.fdma.go.jp/publication/portal/post1.html>）より抜粋し、JITCOが作成

JITCO-гоос, Японд амьдардаг гадаад хүмүүст зориулсан оршин суух хөтөч ном “Япон дахь амьдралын танилцуулга”-ыг 13 орны хэлээр гарган, худалдаалж байна. JITCO сурах бичгийн онлайн дэлгүүрт зарим хэсгийг нь уншиж үзэх боломжтой болохоор, сайтаар ороод үзээрэй гэж урьж байна.



Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо баримтлах



ёс дүрмийг нь нягтлаарай.

✓ Метро, автобусан дотор чанга дуугаар ярьж болохгүй. Мөн, утсаар ярихыг хориглодог. Чихэвчний дуу бусдад сонсогдохоос мөн болгоомжлоорой.



✓ Өөр зорчигчид байгаа тохиолдолд, суух хүртлээ эгнээнд жагсаж хүлээнэ. Эгнээний дундуур орж болохгүй. Хаалганд ойрхон хэсэгт том зай үлдээж, буух хүмүүс бууж дууссаны дараа суугаарай. (Японд буух хүмүүс түрүүлж буудаг зарчимтай.)



✓ Хүн ихтэй үед, үүргэвч г.м овор ихтэй цүнх барьж яваа бол гартаа унжуулж барих юм уу суудлын дээрх ачааны тавиурт тавих зэргээр бусдад төвөг болохгүй байх арга олоорой.



✓ Шинкансэн болон хол зорчих автобуснаас бусад шугамын метро, автобусан дотор ууж идэхийг хориглодог зарчимтай. Шингэн авах г.м зайлшгүй уух шаардлагатай тохиолдолд асгахаас болгоомжлоорой.

優先席 PRIORITY SEAT

Метро, автобус зэрэгт ийм тэмдэгтэй “Тусгай суудал” байдаг. Тусгай суудал нь өндөр настан, тахир дутуу, жирэмсэн хүмүүс болон бага насны хүүхэд дагуулсан хүмүүсийг суулгахад санаа тавих шаардлагатай суудал юм. Метронд хүн цөөхөн байгаа үед бол хэн ч сууж болох боловч, тусгай хүн орж ирвэл, дуудан, суудлаа тавьж өгөөрэй.

とも

2026年1月 冬季号

2026年1月1日発行

発行

電話
JITCO ホームページ

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)
総務部広報室
〒108-0023
東京都港区芝浦2-11-5
五十嵐ビルディング
03-4306-1166 (ダイヤルイン)
<https://www.jitco.or.jp/>



jitco.official



@jitco_official